



**ХЭНГИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 06 сарын 15 өдөр

Дугаар 5/77

Хэрлэн сум

Б.Батсайханг ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.4, 67.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56,1 дэх хэсэг, Засгийн газрын 2019 оны 276 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын зэрэглэл, 2022 оны Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай 488 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтаар баталсан “Эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг”-г тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Батсуурийн Батсайханыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Аж ахуйн тасгийн жолоочоор 2023 оны 6 дугаар сарын 15-ний өдрөөс томилсугай.

2.Б.Батсайханы сарын үндсэн цалинг ТҮ-3 зэрэглэлээр тогтоон, 615,152 (зургаан зуун арван таван мянга зуун тавин хоёр) төгрөгөөр тооцож олгохыг Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д үүрэг болгосугай.

3.Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, тогтоолын шийдвэр, байгууллагын дотоод журам, ажлын байрны тодорхойлолтод заагдсан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг Б.Батсайханд үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.ГАНТУЛГА

